Тайлант онд нийт нэмэгдсэн 144,635.4 мянган төгрөгийн бараа материалын 114,778.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 29,856.4 мянган төгрөгийн хөрөнгө нь аймгийн онцгой комисс болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон бөгөөд ЗДТГ-т шилжүүлэн авч бүртгэсэн байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,568,582.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,579,273.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,097,963.5	1,519,506.3	(3,578,457.2)
Барилга, байгууламж, орон сууц	3,653,250.6	800,356.7	(2,852,893.9)
Авто-тээврийн хэрэгсэл	265,524.4	180,114.8	(85,409.6)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	694,316.9	253,354.1	(440,962.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	256,037.0	54,281.1	(201,755.9)
Бусад үндсэн хөрөнгө	201,126.3	231,399.5	30,273.3
Дуусаагүй барилга, байгууламж	0.0	0.0	0.0
Зам, гүүрийн байгууламж	0.0	0.0	0.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	931.6	0.0	(931.6)
Ном	26,776.6	0.0	(26,776.6)
Биет бус хөрөнгө	49,892.5	49,076.2	(816.3)
Программ хангамж	2,430.0	5,760.0	3,330.0
Бусад биет бус хөрөнгө	47,462.5	43,316.2	(4,146.3)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0	0.0
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0	0.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	0.0	0.0	0.0
Дүн	5,147,855.96	1,568,582.5	(3,579,273.5)

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,568,582.5 мянган төгрөг болж өмнөх оноос 3,579,273.5 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төв 1,547,273.7 мянга, Соёлын төвийн 820,800.6 мянга, Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсантай холбоотойгоор Ерөнхий боловсролын сургууль 954,900.8 мянга, Цэцэрлэг 439,524.6 мянга нийт 3,762,499.8 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	12,118.5	14,788.5	2,670.0	0.9
ЗДТГ	1,373,237.6	1,553,793.9	180,556.3	99.1
ЭМТ	1,547,273.7		(1,547,273.7)	
Соёлын төв	820,800.6		(820,800.6)	
Цэцэрлэг	439,524.6		(439,524.6)	
Сургууль	954,900.9		(954,900.9)	
Дүн	5,147,855.9	1,568,582.4	(3,579,273.5)	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нэмэгдсэн 183,226.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 91.8 хувь буюу 168,258.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Үүнд: Баянбулаг сумын ЗДТГ нь Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газраас 23,883.1 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй, мөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 143,431.3 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

2022 оны эхний үлдэгдэл	5,147,855.9
Нэмэгдсэн	
Худалдан авсан	14,968.0
Шилжүүлэн авсан	23,883.1
Бусад	144,375.2
Хасагдсан	
Бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн	3,762,499.8
2022 оны эцсийн үлдэгдэл	1,568,582.5

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,865.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,305.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	41,479.1	1,748.7	(39,730.4)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,189.7	0.0	(11,189.7)
Байгууллагад төлөх өглөг	8,501.6	116.8	(8,384.8)
Дүн	61,170.4	1,865.5	(59,305.0)

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 1,865.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЗДТГ-ын ажилчидтай холбоотой өглөг 1,748.7, байгууллагад өгөх өглөг 116.8 мянган төгрөг байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 11. Өглөгийн дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эзлэх хувь
Соёлын төв	314.1		(314.1)	0.0
Засаг даргын тамгын газар	0.5	1,865.5	1,865.0	100.0
Эмнэлэг	59,655.8		(59,655.8)	0.0
Сургууль	1,200.2		(1,200.2)	0.0
Дүн	61,170.5	1,865.5	(59,305.1)	100.0

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,464,230.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,014,129.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,558,392.2	307,031.8	(1,251,360.4)
Хуримтлагдсан үр дүн	2,099,040.8	1,141,226.4	(957,814.4)
Өмнөх үеийн үр дүн	2,063,701.1	4,105,962.0	2,042,260.9
Тайлант үеийн үр дүн	35,339.7	-2,964,735.6	(3,000,075.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	820,926.7	15,971.9	(804,954.8)
Дүн	4,478,359.7	1,464,230.1	(3,014,129.6)

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 1,464,230.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,014,129.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр буурсантай холбоотой байна.

3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.17-ний өдрийн хуралдаанаар 04/04 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 162,050.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3,000.0 мянга, нийт 165,050.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсвийн тодотголыг ИТХ-ын 2022.06.09-ны өдрийн 07/03 тогтоолоор татварын орлогыг 185,050.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3,000.0 мянга, нийт 185,050.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
ИОТХ	20,000.0	9,866.5	10,133.5	49.3
хадгаламжийн хүүгийн орлого	34,000.0	27,489.5	6,510.5	80.9
ҮХЭХ борлуулсны албан татвар	3,000.0	316.0	2,684.0	10.5
Бууны татвар	3,000.0	1,110.0	1,890.0	37.0
Улсын тэмдэгт	1,500.0	621.0	879.0	41.4
Газрын төлбөр	2,300.0	1,023.6	1,276.4	4.5
Ан агнуур	-	160,190.4	(160,190.4)	
Ус рашаан	-	-		
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	10,000.0	2,892.1	7,107.9	28.9
ТТАМАТөлбөр	500.0	350.0	150.0	70.0
Малын тоо толгойн татвар	20,000.0	19,935.4	64.6	99.7
ҮХЭХ-ийн татвар	750.0	482.3	267.7	64.3
Хүү торгууль	3,000.0	1,290.0	1,710.0	43.0
ЦХТА орлого /суутган-1/	87,000.0	117,070.4	(30,070.4)	134.6
Татварын орлого	185,050.0	342,637.0	(157,587.2)	185.2
Татварын бус орлого	1,000.0	1,000.0	0.00	100.0
Нийт орлогын дүн	186,050.0	343,637.2	(157,587.2)	184.7

Эх сурвалж: Баянбулаг сумын ИТХ-ын тогтоол

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 157,587.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл ан агнуурын орлогыг тухайн жил татварын орлогоор төлөвлөөгүй бөгөөд гүйцэтгэлээр 160,190.4 мянга, харин цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг 30,070.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,206,404.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,025,766.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 865,174.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 160,591.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.17-ний өдрийн 04/04 дүгээр тогтоолоор нийт 1,242,180.3 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт 13. Төсвийн төлөвлөлт

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	98,521.5	122,778.3	24,256.8
Засаг даргын Тамгын газар	502,431.9	375,730.0	(126,701.9)
Сургууль		170,404.3	170,404.3
Цэцэрлэг		76,839.6	76,839.6
Эрүүл мэндийн төв		33,260.3	33,260.3
Соёлын төв		57,136.2	57,136.2
Сум хөгжүүлэх сан		175,704.3	175,704.3
Орон нутгийн хөгжлийн сан		230,327.3	230,327.3
Нийт дүн	600,953.4	1,242,180.3	641,226.9

Эх сурвалж: Баянбулаг сумын ИТХ-ын тогтоол

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн 04/04 дугаар тогтоолоор анх 1,242,180.3 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.09-ний өдрийн 7/03 дугаар тогтоолоор 35,776.4 мянган төгрөгөөр бууруулж 1,206,404.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 185050.0 мянган төгрөгийг сумын төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогоос, 161,902.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 569,958.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 91,042.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 198,451.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 180,638.2 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн ба орон нутгийн төсөвт 32,866.8 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төвлөрүүлэлт
Засаг даргын Тамгын газар	392,329.3	389,160.6	3,168.7	99.2	4,827.5
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	125,380.2	120,476.4	4,903.8	96.1	4,903.8
Соёлын төв	61,758.2	58,419.9	3,338.3	94.6	3,338.2
Сум хөгжүүлэх сан	176,068.3	100,631.0	75,437.3	57.2	-
Сургууль	128,055.0	125,761.1	2,293.9	98.2	5,049.2
Цэцэрлэг	52,213.6	51,354.2	859.4	98.4	859.4
Эрүүл мэндийн төв	33,260.3	19,371.6	13,888.7	58.2	13,888.7
Орон нутгийн хөгжлийн сан	237,339.6	160,591.5	76,748.1	67.7	-
Нийт дүн	1,206,404.50	1,025,766.30	180,638.20	85.0	32,866.8

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 85.0 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 3,168.7 мянга, ИТХ-ын төсвийг 4,903.8 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 2,293.9 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 859.4 мянга, Эрүүл мэндийн төвийн төсвийг 13,888.7 мянга,

орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 76,748.1 мянга, Соёлын төв 3,338.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 1,300.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 36,812.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 28,862.9 мянган төгрөгийг зарцуулж 9,249.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,300.0	36,812.0	38,112.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.00		1,300.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		36,812.0	36,812.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого			0.0
НИЙТ ЗАРЛАГА	1290.4	27572.5	28862.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1290.4	27572.5	28,862.9
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			0.0
Хөрөнгийн зардал			0.0
Төсөвт төвлөрүүлсэн	9.7	9239.5	9,249.2

Эх сурвалж: Баянбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 50,553.2 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 50,553.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 78.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.5.5 Аудитын гол асуудал

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 186,050.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 343,637.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 184.7 хувь буюу 157,587.2 сая төгрөгөөр давж биелсэн нь төлөвлөгдөөгүй ан агнуурын орлогоос 160,190.4 мянган төгрөг

орсон нь голлох нөлөө үзүүлжээ. Харин иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 10,133.5 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 6,510.5 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 7,107.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянбулаг сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1			1					
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
НИЙТ ДҮН	4	4			4					

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 17,654.7 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ЗДТГ	2	15,212.0	2	15,212.0			2	15,212.0		
ИТХ	2	2,442.7	2	2,442.7			2	2,442.7		
Дүн	4	17,654.7	4	17,654.7			4	17,654.7		

Нийт илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн 129,361.9 мянган төгрөгийн 7, нийцлийн аудитын асуудалтай холбоотой 3 зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Баянбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ЗДТГ	8	142,304.0	2	15,212.0	1	1,389.1	3	121,434.9	2	4,268.0
ИТХурал	3	4,712.6	2	2,442.7					1	2,269.9
СТА зөрчлийн дүн	11	147,016.6	4	17,654.7	1	1,389.1	3	121,434.9	3	6,537.9
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	2	0					1	0	1	0
ИТХурал	1	0					1	0		
Нийцлийн аудитын дүн	3	0	0	0	0	0	2	0	1	0
Нийт дүн	14	147,016.6	4	17,654.7	1	1,389.1	5	121,434.9	4	6,537.9

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
Харьяа төсвийн байгууллагуудын дүн					
Засаг даргын тамгын газар		147,016.6			
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл					
1	Тайлант хугацаанд ЗДНХ-өөс зарцуулсан 19486.5 мянган төгрөгийн спортын тэмцээн уралдаан, шатахуун, худалдан авсан бараа бүтээгдэхүүний зарцуулалтын тайланг гаргаагүй, хяналт хэрэгжүүлээгүй байна.	19486.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
2	Шатахууны тайланг жолоочийн тооцооны хуудастай тулган шалгахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, сургалт, баяр наадмын зардалд нийт 1389.1 мянган төгрөгийг шатахууны зарцуулсан байна.	1389.1	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
3	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 1200.0 мянган төгрөгийн өртөг бүхий Пос машиныг худалдан авсан байна.	1200.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
4	Тайлант хугацаанд байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй 4104.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг худалдан авсан байна.	4104.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
5	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1987 онд ашиглалтад орсон 97,844.4 мянган анхны өртөгтэй "Японы 60 мотор" гэсэн нэр бүхий хөрөнгө нь биетээр байхгүй байна..	97,844.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
6	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022.12.23-ны өдөр 3068.0 мянган төгрөгийн өртөг бүхий цагдаагийн багаж тоног төхөөрөмжийг бэлтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2 дахь заалтыг зөрчиж байна.	3068.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
	Дүн	142,304.0			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2-д заасны дагуу горим сорил хэрэгжүүлэхэд өмнөх оноос бичиг хэргийн зардлыг 1.2 хувь, тээвэр шатахууны зардлыг 4.2 хувиар өсгөсөн байна.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53020.1 мянган төгрөгийн 5 гүйлгээг, зарлагын 14699.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Цэнд-Аюуш, Б.Чимэдцэеэ
	Дүн	0			
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		4,712.6			
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл					
1	ИТХ-ын нарийн бичгийн дарга нь тэтгэвэр тогтоолгосон бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажлын байрны нөхөн томилгоо хийх	2269.9	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ч.Ганболд, Б.Чимэдцэеэ

Аудитын код: БНА-2023/3/НА-СТА-ТТЗ

Хуудас-23

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	хүртэл түр хугацаанд томилсон ч албан тушаалын үндсэн цалин болох ТЗ-9-5-5 дахь цалингаар цалинжсан байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 46.2.3 дахь заалт, мөн Төрийн албаны зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн "Өндөр насны тэтгэвэртэй холбогдох зарим асуудлын тухай" 07 дугаар зөвлөмжийн 8-д заасныг зөрчиж байна.				
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21011.6 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг хугацаа хоцроож, 46680.6 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Ч.Ганболд, Б.Чимэдцэеэ

3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,206,404.5 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,025,766.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,206,404.5	1,025,766.4	180,638.1	85.0
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	125,380.2	120,476.4	4,903.8	96.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	83,699.6	78,795.8	4,903.8	94.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	35,367.4	35,367.4	-	100.0
80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	6,313.2	6,313.2	-	100.0
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	392,329.3	389,160.6	3,168.7	99.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	265,658.7	264,051.7	1,607.0	99.4
80106 Баг, хорооны ҮАЗардал	53,861.9	53,127.5	734.4	98.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,000.0	1,000.0	-	100.0
80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг	10,255.5	9,428.2	827.3	91.9
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	50,553.2	50,553.2	0.0	100.0
81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	1,000.0	1,000.0	-	100.0
82212 Хур хог хаягдал, орчны бохирдол	10,000.0	10,000.0	-	100.0
70503 Орон нутгийн зорилтот Х Оруулалт	237,339.6	160,591.5	76,748.1	67.7
80904 Нийгмийн зориулалттай барилга	55,437.4	55,104.0	333.4	99.4
83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	124,617.9	68,843.1	55,774.8	55.2
83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	12,040.8	8,091.5	3,949.3	67.2
83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар	20,000.0	11,579.0	8,421.1	57.9
83406 ОНХС - Бусад	25,243.5	16,974.0	8,269.5	67.2
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	33,260.3	19,371.6	13,888.7	58.2
80112 Нийтлэг үйлчилгээ	33,260.3	19,371.6	13,888.7	58.2
71702 Соёл урлаг	61,758.2	58,420.0	3,338.2	94.6
80112 Нийтлэг үйлчилгээ	61,758.2	58,420.0	3,338.2	94.6
71801 Сургуулийн өмнөх боловсрол	52,213.6	51,354.2	859.4	98.4
80112 Нийтлэг үйлчилгээ	52,213.6	51,354.2	859.4	98.4
71802 Ерөнхий боловсрол	128,055.0	125,761.1	2,293.9	98.2
80112 Нийтлэг үйлчилгээ	128,055.0	125,761.1	2,293.9	98.2
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	176,068.3	100,631.0	75,437.3	57.2
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	176,068.3	100,631.0	75,437.3	57.2

Эх суралж: Баянбулаг сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын

Аудитын код: БНА-2023/3/НА-СТА-ТТЗ

Хуудас-24

31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгий тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,266,633.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,999.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 23,800.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сумын хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд захиргааны зориулалттай шинээр байшин барилга тусгаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно” гэсэн заалттай нийцэж байна.

Баянбулаг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Баянбулаг сумын ЗДТГ нь өмнөх оноос бичиг хэргийн зардлыг 1.2 хувь буюу 51.9 мянга, тээвэр шатахууны зардлыг 4.2 хувь буюу 882.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зөрчил илэрсэн.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 16. Шилэн дансны мэдээлэл

дд	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	8	4	
2	Хагас жил	3	3	0	3	
3	Улирал бүр	2	8	2	6	
4	Сар бүр	5	60	56	4	
5	Тухай бүр	6	72	69	3	
Нийт дүн		28	155	135	20	

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба асуудлын бүртгэлийг танилцуулсан, жилийн эцсээр дүнг нэгтгэн танилцуулсан болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 38,574.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	79,181.9	0	23,407.0	1	55,774.9	30
Зөвлөмж	3	38,574.9	3	38,668.2	0	0	100
Нийт	4	117,756.8	3	62,075.2	1	55,774.9	65

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2149.7 мянган төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 2,149.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулав.

1. Хоршоо хөгжүүлэх сангийн үр дүнгийн тайлангийн орлогыг 1,399.7 мянга, зарлагыг 750.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн тул үр дүнгийн тайланд залруулав.

Аудитаар нийт 38,629.3 мянган төгрөгийн зөрчил³ илэрсэн тул алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татварын орлогыг 20,000.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 19,935.4 мянган төгрөг төвлөрсөн ч сумын ОНХС-ийн дансанд 16,000.0 мянга буюу 3,935.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй орон нутгийн орлогын дансанд үлдэгдлээр байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварыг сумын ОНХС-д бүрэн төвлөрүүлж ажиллах.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн хуралдаанаар анх батлахдаа сумын төсвийн нийт зарлагыг 1,242,180.9 мянган төгрөгөөр баталсан ч санхүүжүүлэх эх үүсвэрийг 34,693.9 мянган төгрөгөөр дутуу буюу 1,207,486.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Сумын Засаг дарга ИТХ-ын хуралдаанд орлогын төсвийг өргөн барихдаа, орлогын эх үүсвэрийг үнэн зөв тусгаж байх.

3. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллээс 3, сар бүр мэдээлэх мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож, улирал бүр мэдээлэх мэдээллээс 6, хагас жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 3, бүтэн жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос газрын төлбөр 1276.4 мянга, бууны татвар 1890.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 7,107.9 мянга, малын тоо толгойн албан татварын орлого 197.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

5. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянбулаг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь биетээр байхгүй хөрөнгийг тоолсон, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр гараагүй байхад сэлбэг хэрэгсэл худалдан авсан, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга, төсвийн захирагч нар хяналт тавьж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа төсөвт байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих сумын өмч хамгаалах зөвлөл, санхүүгийн албаны хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянбулаг сумын Засаг дарга	1	2,149.7	1	2,149.7			1	2,149.7				
Дүн	1	2,149.7	1	2,149.7			1	2,149.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянбулаг сумын Засаг дарга	4	38,629.3					4	38,629.3				
Дүн	4	38,629.3					4	38,629.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Баянбулаг сумын Засаг дарга	1	0						1	0
Дүн	1	0						1	0